

ХҮЧИРХЭГ УЛСТАЙ ӨРСӨЛДӨЖ, СУРАЛЦАЖ БАЙЖ ХӨГЖИНӨ

Монголбанктай хамтын ажиллагааны харилцан ойлголцлын санамж бичиг байгуулахаар энэ сарын 14-15 хооронд Монголд айлчилсан Өмнөд Солонгосын Төв банкны Ерөнхийлөгч Чонсу Ким гол ажлаа амжуулсныхаа дараа өчигдөр монголын санхүүгийн салбарын ажилтнуудад “Солонгосын эдийн засгийн амжилт: Стратеги, сорилт, туршлага” гэсэн сэдэвтэй илтгэл монголын санхүүгийн ажилтнуудад уншлаа.

1951 онд нэг хүнд ноогдох ДНБ нь 82 ам.доллар байсан бол 2010 онд 20,759 ам.доллар болтлоо өссөн Өмнөд Солонгосын эдийн засаг жаран жилийн дотор гадны туслалцаа авдаг орноос туслалцаа өгдөг орон болтлоо хөгжсөн. Гэхдээ эдийн засгийн өсөлт саад бартаатай, хямралтай байсан гэж Чонсу Ким илтгэлийнхээ эхэнд дурдсан юм.

1951 онд Өмнөд Солонгосын инфляци 360 хувь хүрч байсан удаатай гэнэ. Тэр үед эдийн засаг нь гадаадын зээл тусламжад тулгуурлаж, жилд дунджаар 3.8 хувийн өсөлттэй байж.

Харин 1961 оноос хойш эдийн засгийн таван жилийн төлөвлөгөөг боловсруулж, 1962 оноос гучин жил хэрэгжүүлжээ. Бодлогын маш том өөрчлөлтүүдийг тэр үед хийж, импортыг орлосон бүтээгдэхүүнийг үйлдвэрлэдэг эдийн засгаас экспортыг дэмжсэн эдийн засаг руу шилжсэн байна. Байгалийн баялаг бараг байхгүй, хүн амын нягтаршил ихтэй тус улс экспортыг дэмжихгүйгээр өнөөгийн хөгжлийн түвшиндээ хүрэхгүй байсан гэдгийг Чонсу Ким онцолсон юм. Дашрамд дурдахад, 2010 онд тус улс дэлхийн зургаа дахь хамгийн том экспортлогч, арав дахь хамгийн том импортлогч орон болсон билээ.

Чухам Өмнөд Солонгосын таван жилийн төлөвлөгөө, тухайн үеийн социалист орнуудын таван жилийн төлөвлөгөөнөөс юугаар ялгаатай вэ гэдгийг Чонсу Ким эдийн засгийн баялгийн хуваарилтыг зөв зохистой хуваарилсанд оршино гэж хэлж байлаа. Зардал-бүтээгдэхүүний харилцааг зөв зохицуулснаар Өмнөд Солонгосын таван жилийн төлөвлөгөө амжилттай хэрэгжжээ. Засгийн газрын дэмжлэгтэйгээр гадагш чиглэсэн экспортыг ихэсгэж, үйлдвэрлэлээ шат дараатай хөгжүүлсэн байна. Урт хугацаанд бодлого тууштай хэрэгжүүлэхэд таван жилийн төлөвлөгөө их чухал үүрэг гүйцэтгэсэн байна. Гучин жилийн хугацаанд аж үйлдвэрийн салбараа үе шаттайгаар хөгжүүлснээр Өмнөд Солонгос хөдөө аж ахуй давамгайлсан ядуу буурай орноос аж үйлдвэржсэн орон болж чаджээ. Гадаадын хөрөнгө оруулалтыг энэ үед их дэмжиж байж. Тиймээс ч их өр зээлтэй орон болжээ.

Хэдийгээр таван жилийн төлөвлөгөө 30 жил амжилттай хэрэгжсэн ч бас сөрөг үр дагаврыг авчирчээ. Засгийн газрын оролцоо их байсан тул зах зээлийн зарчмыг зөрчиж, ингэснээр инфляцийг хөөрөгдөх нэг шалтгаан болжээ. Тиймээс Засгийн газар нь аажмаар эдийн засагт оролцох үүргээ багасгаж, төлөвлөгөөг заавал биелүүлэх гэж зорих биш харин эдийн засгийн хөгжлийг чиглүүлж өгөх үүргийг гүйцэтгэх болсон байна. Хувийн хэвшлийнхэнд илүү их боломжийг олгож, Засгийн газар нь ерөнхий хөгжлийн чиг хандлагыг гаргах болжээ. Ингэхийн тул нийт ард иргэддээ хөгжлийн чиг хандлагаа зөв таниулсан чухал аж.

1990-ээд оноос Өмнөд Солонгосын эдийн засаг экспортыг дэмжсэн бодлогоо өөрчилж тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг баримтлах болсон байна. Үүнийхээ ачаар инфляцийг тодорхой хувиар бууруулж чадсан байна. Мөн 1990-ээд оны дундаас эдийн засгийн чөлөөт бодлогыг хэрэгжүүлж эхэлжээ.

Зөвхөн дотоодын эдийн засгаа гэлгүй олон улсын зах зээлийн хөгжлийн хандлагыг тооцож ирээдүйг харсан хөгжлийн стратегийг боловсруулах нь чухал гэдгийг Чонсу Ким онцолж байлаа. Нэн ялангуяа байгалийн баялаг ихтэй манай улсын хувьд энэ их чухал гэнэ. Мөн уян хатан эдийн засгийн бодлого хэрэгжүүлэх хэрэгтэйг тэрээр онцоллоо. Өнгөрсөн 50 жилийн хугацаанд Өмнөд Солонгос зөвхөн ганц бодлогыг хэрэгжүүлээгүй. Тухай үеийн эдийн засгийн нөхцөл байдлаасаа шалтгаалан бодлогоо өөрчилж өнөөгийн хөгжилд хүрчээ. 1950-д оноос импортыг орлосон бүтээгдэхүүн үйлдвэрлэх, 1960-д оноос экспортыг дэмжсэн. 1980-д оноос эдийн засгийн тогтвортой өсөлтийг, харин 1990-д оноос эдийн засгийн чөлөөт байдлыг илүү анхаарчээ.

Зах зээлийн зарчмыг баримтлах нь бас чухал гэдгийг тэрбээр дурдсан. Өмнөд Солонгосын хөгжлийн эхний үед эдийн засагт дахь төрийн оролцоо их байсныг аажмаар багасгасан байна. Монополь их, эсвэл хэрэглэгчид цөөхөн байхад эдийн засаг хөгжихгүй. Олон нийлүүлэгч, олон хэрэглэгчид байвал эдийн засаг хөгжих тул эдийн засгийг нээлттэй, ардчилсан байлгах хэрэгтэй тул Өмнөд Солонгос Европын холбоотой чөлөөт худалдааны гэрээ байгуулсан байна. Удахгүй АНУ-тай чөлөөт худалдааны гэрээ байгуулахаар болж байгаа гэнэ. Хэдийгээр Өмнөд Солонгост “Хэт хүчирхэг улсуудтай чөлөөт худалдааны гэрээ байгуулчихвал хохиролтой” гэж эсэргүүцсэн хүмүүс байсан ч хүчирхэг улсуудтай өрсөлдөж байж хөгжинө гэсэн байр суурийг Өмнөд Солонгосын Засгийн газар баримталжээ. Өөрөөсөө илүү хүчирхэг оронтой өрсөлдөж, суралцаж байж улс орон хөгжих ёстой аж.

Тэрбээр мөн, байгалийн баялаг ихтэй орны эдийн засаг байнга өсч байдаг ч, байнга хямрах аюултай байдаг. Тиймээс ашигт малтмалын салбарыг хөгжүүлэхээс гадна өөр салбарыг хөгжүүлж, өөрийн эдийн засагт тохирсон эдийн засгийн стратегийн бодлогыг боловсруулах хамгийн чухал. Аль нэгэн улсын эдийн засгийн стратегийн бодлогыг Монголд тэр чигээр нь хэрэгжүүлэх зохимжгүй тул улсынхаа өрсөлдөх чадварын давуу болон сул талыг сайн мэдэж байж стратегийн бодлогоо хэрэгжүүлэх хэрэгтэй. Гэхдээ гадаад зах зээлтэйгээ уялдсан стратеги боловсруулах чухал. Монгол хүн ам цөөтэй учир зах зээлийн эрэлт бага. Ийм орны хувьд гадаадын зах зээлд нээлттэй байж чадахгүй бол өрсөлдөх чадвар буурна гэв.

Мөн ирээдүйгээ харсан бодлого их чухал гэнэ. Жишээ нь, 1968 онд анхны хурдны замыг Өмнөд Солонгосын Засгийн газрын санаачлагаар барьж эхлэхэд ард иргэд нь нэлээн эсэргүүцжээ. Учир нь хувийн машинтай иргэд цөөхөн байжээ. Хэрэв тэр үед хурдын зам барих ажлыг зогсоосон бол хожим нь газар үнэд орж улам өндөр өртөгтэй барих байжээ. Мөн тухайн үед санхүүжүүлэлт олох хэцүү байж. Дэлхийн банк “Танайх шиг ядуу оронд хурдны зам хэрэгтэй юм уу?” гэж асууж байжээ. Гэвч солонгосчууд ирээдүйгээ харч чадсаны хүчинд хөгжлийнхөө түүхэнд хамгийн чухал үүргийг гүйцэтгэсэн төслийг хэрэгжүүлж чадсан байна.

Байгалийн баялаг ихтэй орон эдийн засгийн огцом өсөлтийн үед эдийн засаг нь зөв замаар явж байна уу, үгүй юу гэдгийг ухаарч амжилгүй зарлагаа ихэсгэдэг муу зуршил байдаг тул чадвараасаа хэтэрсэн хэрэглээг хязгаарлах хэрэгтэйг Чонсу Ким мөн сануулж байлаа.

Итгэлийн төгсгөлд Монголбанкны Ерөнхийлөгч Л.Пүрэвдорж, Чонсу Кимд Өмнөд Солонгосын эдийн засгийн амжилтын талаар дэлгэрэнгүй илтгэл тавьсанд талархан “Монголбанканд том хөрөнгө оруулалт хийлээ” гэж хэлэв.

МОНЦАМЭ МЭДЭЭ